

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

Тайлант хугацаанд 165.0 мянган тонн цемент, 165.5 мянган тонн чулуунцар, 23.2 мянган тонн шохой, үйлдвэрлэх төлөвлөгөөт зорилт тавьж 105.3 мянган тонн цемент үйлдвэрлэн төлөвлөгөөт зорилтыг 64%, чулуунцар 127.0 мянган тонн үйлдвэрлэж 77%, 22.3 мянган тонн шохой үйлдвэрлэж 96 % тус тус зорилтыг ханган ажилласан.

2023 оны эхэнд үйлдвэрийн хэмжээнд 6503 тонн цемент, 2788 тонн шохой, 15903 тонн клинкерийн нөөцтэй байсан бол ЭХЖилийн байдлаар 6889 тонн цемент, 4265 тонн шохой, 49752 тонн клинкерийн нөөц бүрдүүлж ажилласан.

Үзүүлэлт	нэгж	2023 оны ЭХЖ			Хэлбэлзэл		
		2022	2023	2023	Хэлбэлзэл	2023	2023 гүйц/
		гүйц	төл	гүйц		гүйц/төл	2022 гүйц
Хэлбэлзэл							
Хэлбэлзэл							
Үйлдвэрлэлтийн хэмжээ							
Цемент	тонн	188,209.6	165,000	105,323	-59,677	64%	56%
Шохой	тонн	27,546.0	23,200	22,342	-858	96%	81%
Чулуунцар	тонн	188,076.0	165,500	127,048	-38,453	77%	68%
Борлуулалтын хэмжээ							
Цемент	тонн	196,913.2	165,000	104,937	-60,062.7	64%	53%
Шохой	тонн	24,662.9	23,200	20,866	-2,334.3	90%	85%

Цемент:

Цементийн үйлдвэр нь 2023 оны эхний хагас жилд 165,000тн цемент үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байсанаас технологийн зааврын дагуу стандартад нийцсэн PPC32,5 OPC42,5 PC52,5 ангийн нийт 105,326 тн цементийг үйлдвэрлэсэн. Төлөвлөгөөний биелэлт 64 хувьтай байна.

Барилгын салбарын ажлууд оройтож эхэлсэн зэрэг нь манай үйлдвэрийн борлуулалтад нөлөөлж эрэлт буурснаас шалтгаалан цементийн нөөцийн силос агуулахын хүрэлцээ муугаас цемент үйлдвэрлэлтийн төлөвлөгөө тасарсан.

Үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт:

Цехийн нэр	Үзүүлэлт	2023 оны ЭХЖ дүнгээр			
		төл	Гүй	хувь	
Цемент	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	165,000	105,323	64%	
	Хуанлийн хоног	181	181	0.0	
	Ажиллах тээрэм	3	3	0.0	
	Ажилласан цаг	3,837	2,170	-1667.0	
	Сул зогсолт	Үүнээс:	8,835	10,862	2027.0
		Улирлын	6,480	6,379	-101.4
		Техникийн	2,355	1,341	-1013.8
		Зогсоох галлах	-	-	0.0
		төлөвлөгөөт бус	-	3,142	3142.2
	Хүчин чадал ашиглалт		43.0	48.5	113%

=

Хүчин чадал ашиглалтын дэлгэрэнгүй тайлбарлавал:

Цементийн үйлдвэр нь хуанлийн хоногоор 181 өдөр буюу 13032 цагаас улирлын чанартай 6480 цаг, төлөвлөгөөт засварт 2355 цаг зогсож 3837 цаг ажиллаж цагийн хүчин чадал 43 тн/цаг-тай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр цагийн хүчин чадал 48.4 тн/цагтай 2170 ажилласан.Төлөвлөгөөгүй сул зогсолт 3142 цаг

Төлөвлөгөөт бус сул зогсолтын шалтгаан:

- Механик 116 цаг: Цементийн тээрмүүдийн шугам цоорох, ачааллах болон хийний хаалт солих, хагарсан брони солих, тосны , туслах редукторын засвар винтеляторын суурийн боолтны засвар гэх мэт механик саатлаас зогссон.
- Технологи-58 цаг: Цементийн тээрмүүдийн завсар төгсгөлийн хана бөглөрөх, цементийн температур өсөх, цемент алдах гэх мэт технологи зогссон.
- Кран 13 цаг: Краны зам солисон
- Цахилгаан 86 цаг : Хэт ачаалалын хамгаалалтын релей, давтамжийн хувиргуур, тосны станцын реле гэх мэт цахилгаан саатлаас болж зогссон.
- Цахилгаан эрчим хүчний хэмнэлтээр 185 цаг : 17-22 цагын хооронд цахилгааны хамгийн өндөр тарифтай тул силосын нөөцөөс хамаарч ажилласан
- Нөөцөнд -2671 цаг: Цементийн силосууд дүүрэн.

Чулуунцар:

Чулуунцарын үйлдвэрийн тухайд өвлийн улирлын зогсолт, засварын ажлууд дуусаж 2023 оны үйлдвэрлэлт 03 сарын 27-ны өдрөөс эхэлсэн.

Компанийн 2023 оны зорилтот түвшинд тусгасанаар чулуунцарын үйлдвэрийг 2023 оны 03 сарын 01-ээс эхлүүлэхээр төлөвлөж байсан боловч, 2023 оны хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/, ТУЗ-н дэргэдэх аудитын хороо, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Сангийн яаманд шат дараатайгаар хянуулан, Сангийн яамнаас 2023 оны 01 сарын 25-нд www.tender.gov.mn цахим сайтад байршуулан 2023 оны 02 сарын 01-ээс эхлэн худалдан авалтын тендер сонгон шалгаруултыг хийж эхэлсэн.

Компанийн зүгээс тендер сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулж шаардлагатай сэлбэг бараа материалыг 03 сарын 15 гэхэд татан авч үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварын ажлыг дуусгаж үйлдвэрийг 03 сарын 27-ний өдрөөс эхлэн ажилуулж эхэлсэн.

2023 оны хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөг батлуулахад анх удаа хувийн хэвшлээс төрийн өмчит хэлбэрт шилжсэн, хууль, дүрэм журмын хүрээнд шат дараатай олон газраар худалдан авалтын төлөвлөгөөг хянуулах, батлуулах зэргээс улбаалан 02 сарын 01-ээс тендер сонгон шалгаруулалтын ажлыг эхэлсэн нь Чулуунцарын үйлдвэр төлөвлөгөөнөөс 26 хоног хойшилж ажилласан үндсэн шалтгаан болсон. Цаашид худалдан авалтыг дараа оны 01 сарын 01-ээс эхлүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай юм.

Эхний хагас жилийн байдлаар нийт 127.1 мян тн клинкер үйлдвэрлээд байна. Төлөвлөгөөний биелэлт 77%-тай байна.

=

Үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт:

Цехийн нэр	Үзүүлэлт	2023 оны ЭХЖ дүнгээр			
		төл	Гүй	хувь	
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт		165500	127047	77%	
	Хуанлийн хоног	181	181		
	Ажиллах цаг	1727	1432	-295.3	
Чулуунцар	Сул зогсолт	Үүнээс:	2617	2912	295.3
		Улирлын	1416	1704	288.0
		Техникийн	1201	120	-1081.0
		Зогсоох галлах	0	0	0.0
		төлөвлөгөөт бус	0	1088	1088.4
		Хүчин чадал ашиглалт	95.8	88.7	93%

Чулуунцарын үйлдвэр 2023 оны эхний ЭХЖилийн байдлаар 1727 цаг буюу 95.8 тн/цагийн хүчин чадалтай ажиллахаас гүйцэтгэлээр 1432 цаг буюу 88,7тн/цагийн хүчин чадалтай ажиллаж, төлөвлөгөөт засварт 120 цаг зогсож, улирлын чанартай зогсолт 1704 цаг, төлөвлөгөөт бус зогсолт 1088 цаг нийт 2912 цагийн зогсолт гаргаж ажилласан байна. Хүчин чадал ашиглалт төлөвлөснөөс 7.0 тн/цагаар буурснаар 10,2 мян. тн чулуунцар үйлдвэрлэх боломж алдсан.

Төлөвлөгөөт бус сул зогсолтын шалтгаан

Шалтгаан	цаг
Механик	213.8
Цахилгаан	0.7
Технологи	430.6
Цахилгааны саатал	3.9
нарийн хэмжүүр	125.5
Сэлбэггүй	312.0
Бусад	1.8
Нийт	1088.4

2023 оны эдийн засгийн зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эргэх зуухны галд тэсвэртэй доторлогооны тоосго солих төлөвлөгөөт засварын ажил 2023 оны 06 сарын 18-ний өдрөөс эхлэсэн. Өнөөдрийн байдлаар галд тэсвэртэй тоосго болон бусад дагалдах хольц, нерж бэлдэцүүд, галд тэсвэртэй хуурай хольц, цемент зэргийг хуулийн дагуу худалдан авч үйлдвэрийн талбайд авчирсан. Доторлогооны ажил 35%-тай явагдаж байна.

=

Тоног төхөөрөмжүүдийн засварт шаардлагатай гадаад сэлбэг, бараа материалыг Хятад улсаас татан авах ажил хийгдэж байна. Эргэх зуухны форсунк, хөргөгчийн решётка, холхивчны үүр, хөргөгчийн шатун, бутлуурын ротор зэргүүд үйлдвэрийн талбайд бэлэн ирсэн байна.

Шохой:

Шохой үйлдвэрт тохиромжтой нүүрс нь өндөр илчлэгтэй, богино дөлтэй, эрчим хүчний нүүрс байдаг. Дээрх технологийн шаардлагад Тавантолгойн бүлэг ордод үйл ажиллагаа явуулж буй Энержи ресурс ХХК-ийн Нүүрс баяжуулах үйлдвэрээс гарч байгаа мидлинг буюу угааж баяжуулсан эрчим хүчний нүүрс бүрэн нийцдэг.

Төмөр замын ачаа эргэлт, вагоны хүрэлцээнээс хамаарч шохойн үйлдвэрт шаардлагатай нүүрсний асуудал тулгамдсан асуудал болоод байна. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу шохой үйлдвэрлэх технологийн нүүрс худалдан авах тендерийг 2 удаа нээлттэй сонгон шалгаруулалтаар зарласан боловч оролцогч байхгүйн улмаас тендер амжилтгүй болсон. Тендерийн хуулийн 34-р зүйлд заасны дагуу шууд гэрээ байгуулах аргыг ашиглан одоогоор Энержи ресурс ХХК-тай нүүрс худалдан авах гэрээг байгуулан ажиллаж байна.

Эхний хагас жилийн байдлаар нийт 22,397 тн шохойн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Төлөвлөгөөний биелэлт 97%-тай байна.

Үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт:

Цехийн нэр	Үзүүлэлт	2023 оны ЭХЖ дүнгээр			
		төл	Гүй	хувь	
Шохой	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	23,200.0	22,397	97%	
	Хуанлийн хоног	181.0	181.0		
	Ажиллах зуух	2.3	2.0	-0.3	
	Ажиллах цаг	10,140.0	8,286.0	-1854	
	Сул зогсолт	Үүнээс:	2,892.0	4,746.0	1854
		Улирлын	2,160.0	2,128.0	-32
		Техникийн	732.0	720.0	-12
		Зогсоох галлах	-	-	0
		төлөвлөгөөт бус	-	1,898.0	1898
	Хүчин чадал ашиглалт		2.29	2.7	118%

Дэлгэрэнгүй тайлбарлавал:

2023 оны ЭХЖИлийн дүнгээр хуанлын 181 хоног 2.3 зуухаар 10140 цаг ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2.0 зуухаар 8286 цаг ажиллаж 1854 цаг дутуу ажилласан. Төлөвлөгөөт бус 1898 цаг төлөвлөгөөт сул зогсолт гарсан ба 1464 цаг буюу 85 хувь нь нөөцөд буюу нүүрсгүй зогссон. Хэдийгээр 1 зуухыг нөөцөд голдуу зогсоосон ч 2 зуухны хүчин чадлыг цаг тутамд 0,41тн

=

–оор нэмэгдүүлж ажилласнаас 3438 тн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэж төлөвлөгөөт зорилтыг 97хувиар биелүүлсэн.

Уурхайн ажлын төлөвлөгөөний биелэлт:

Үзүүлэлт		нэгж	2023 он		зөрүү	биелэлт хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Хөтөл-1	Өрөмдлөг	у/м	28,342.15	13,697.00	-14,645.15	48%
	Чулуу олборлолт	тонн	251,104.93	229,915.80	-21,189.13	92%
	Сланц	тонн	36,636.00	56,022.55	19,386.55	153%
	Хөрс	м3	550,792.16	402,343.00	-148,449.16	73%
	Нийт уулын цул	м3	657,759.05	508,639.78	-149,119.27	77%
Хөтөл-2	Өрөмдлөг	у/м	0.00	1,611.00	1,611.00	0%
	Чулуу олборлолт	тонн	0.00	23,030.05	23,030.05	0%
	Сланц	тонн			0.00	0%
	Хөрс	м3	0.00	2,140.00	2,140.00	0%
	Нийт уулын цул	м3	0.00	10,701.36	10,701.36	0%
Нийт	Өрөмдлөг	у/м	28,342.15	15,308.00	-13,034.15	54%
	Чулуу олборлолт	тонн	251,104.93	252,945.85	1,840.92	101%
	Сланц	тонн	36,636.00	56,022.55	19,386.55	153%
	Хөрс	м3	550,792.16	404,483.00	-146,309.16	73%
	Нийт уулын цул	м3	657,759.05	519,341.14	-138,417.91	79%

2023 оны эхний ЭХЖилийн байдлаар 28,3 мянган уртааш метр өрөмдлөгийн ажил хийж, 550,8 мян.м3 хөрс хуулж, 287,7 мян.тонн чулуу болон станц олборлох, нийт 657,8 мян.м³ уулын цулын ажил хийхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 15,3 мянган у.метр өрөмдлөг 404,5 мян.м³ хөрс хуулалтын ажил, 308,9 мян. тн шохойн чулуу болон сланц олборлож, нийт 519,3 мян.м³ уулын цулын ажил хийгдсэн. Төлөвлөгөөний биелэлт уулын цулаар 79 хувь.

Төлөвлөлтөөр хөрс хуулалтын коэффициент 2.1-ээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр Хөтөл-1 хөрс хуулалтын коэффициент-1.4, Хөтөл-2 хөрс хуулалтын коэффициент-0,09 байна. Дундажаар хуулалтын коэффициент-1,3 байна. Тиймээс хөрс хуулалтын ажил хоцрогдолтой байна.

“Цемент Шохой” ТӨХК-ийн ЭХЖилийн зардлын шинжилгээ

ЭХЖилийн үйлдвэрлэлийн нийт зардал:

№	Зардал Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	2022	2023	2023	Эзлэх хувь	Хэлбэлзэл	
		гүйц	төл	гүй		2023г/2022г	2023г/2022г
1	Шатах тослох материал	1,209,882.5	2,343,817.3	1,619,475.9	4.0%	(724,341.4)	409,593.4
2	Нүүрс	4,996,747.5	7,695,212.0	5,079,299.7	12.5%	(2,615,912.3)	82,552.2
3	Түүхий эд материал	2,004,442.7	3,619,320.7	1,464,814.4	3.6%	(2,154,506.3)	(539,628.4)
4	Туслах материал	591,243.2	5,948,020.0	1,084,860.6	2.7%	(4,863,159.4)	493,617.3
5	Цалин	8,005,728.2	12,503,888.1	11,515,590.9	28.3%	(988,297.1)	3,509,862.8
6	Нийгмийн даатгал	1,103,578.9	1,688,024.9	1,712,080.2	4.2%	24,055.3	608,501.3
7	Цахилгаан	4,905,203.4	5,940,412.4	4,116,244.3	10.1%	(1,824,168.2)	(788,959.1)
8	Усны зардал	104,114.4	243,304.1	147,648.7	0.4%	(95,655.4)	43,534.3
9	Сав баглаа	556,312.5	898,426.8	349,018.3	0.9%	(549,408.6)	(207,294.2)
10	Сэлбэг материал	2,281,523.9	7,749,850.7	2,783,985.0	6.9%	(4,965,865.7)	502,461.1
11	Тээвэр бэлтгэх ажиллагаа	23,591.9	15,374.9	26,950.3	0.1%	11,575.4	3,358.4
12	Үндсэн хөрөнгийн элэгдэл	5,130,814.1	5,884,215.2	5,231,492.2	12.9%	(652,723.0)	100,678.1
13	Бичиг хэрэг	24,404.3	56,037.2	23,231.0	0.1%	(32,806.3)	(1,173.3)
14	Холбооны зардал	18,747.6	41,776.0	26,905.5	0.1%	(14,870.4)	8,158.0
15	Хөдөлмөр хамгаалал	499,535.3	1,068,977.6	427,801.0	1.1%	(641,176.6)	(71,734.3)
16	Сургалтын зардал	29,175.0	144,422.5	43,820.6	0.1%	(100,601.9)	14,645.6
17	Ариун цэвэр	45,874.1	99,047.3	44,877.2	0.1%	(54,170.1)	(996.9)
18	Зар сурталчилгаа	59,618.4	209,020.0	58,421.4	0.1%	(150,598.6)	(1,197.0)
19	Хүлээн авалт	4,606.0	-	2,040.4	0.0%	2,040.4	(2,565.6)
20	Аж ахуйн тохижилт	65,136.1	117,327.3	91,507.6	0.2%	(25,819.7)	26,371.5
21	Тэтгэмж	208,187.2	125,038.9	209,018.3	0.5%	83,979.4	831.1
22	Түрээсийн зардал	157,340.3	189,454.6	93,619.0	0.2%	(95,835.5)	(63,721.2)
23	Орд ашигласны төлбөр	175,752.4	304,120.5	127,161.6	0.3%	(176,959.0)	(48,590.8)
24	Газрын төлбөр	22,445.1	16,251.0	21,462.1	0.1%	5,211.1	(983.0)
25	Усны төлбөр	4,430.1	11,465.5	4,449.9	0.0%	(7,015.6)	19.7
26	Үл хөдлөх хөрөнгийн зардал	278,558.5	279,233.8	275,495.2	0.7%	(3,738.6)	(3,063.3)
27	Хоолны хөнгөлөлт	221,745.1	289,170.0	364,508.4	0.9%	75,338.4	142,763.2
28	Витаминжуулалт	-	49,560.0	4,380.7	0.0%	(45,179.3)	4,380.7
29	Биет бус хөрөнгийн зардал	60,110.0	63,205.6	86,181.2	0.2%	22,975.6	26,071.2
30	АТӨЯХ татвар	4,519.1	5,717.9	-	0.0%	(5,717.9)	(4,519.1)
31	Томилголт	34,866.0	92,840.0	42,711.3	0.1%	(50,128.7)	7,845.3
32	Бусад зардал	289,283.7	11,195.0	308,876.1	0.8%	297,681.1	19,592.4
33	Шагнал урамшуулал ҮНЗ	-	-	1,012,898.5	2.5%	1,012,898.5	1,012,898.5
34	Төсөвт зардал	5,967.9	10,200.0	1,382.1	0.0%	(8,817.9)	(4,585.8)
35	Даатгал	364.3	-	29,003.3	0.1%	29,003.3	28,639.0
36	Харуул хамгаалалт	349,090.9	409,090.9	349,090.9	0.9%	(60,000.0)	-
37	Байгаль орчны нөхөн сэргээлт	8,737.7	47,027.5	23,875.9	0.1%	(23,151.6)	15,138.2
38	Дулаан	446,015.5	628,186.6	597,434.5	1.5%	(30,752.1)	151,419.1
39	Ашиглалтын зардал	10,799.0	-	10,927.1	0.0%	10,927.1	128.1
40	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	1,921,827.1	2,957,357.6	1,189,260.9	2.9%	(1,768,096.7)	(732,566.2)
41	Хүү торгууль хөнгөлөлт	-	-	-	0.0%	-	-
42	Хүлэмжийн зардал	-	-	-	0.0%	-	-
43	сувицлагын хөнгөлөлт	1,200.0	4,320.0	2,312.0	0.0%	(2,008.0)	1,112.0
44	МӨСТ-ийн зардал	-	-	-	0.0%	-	-
45	спорт урлаг	-	16,790.0	-	0.0%	(16,790.0)	-
46	баяр ёслол	144,977.6	1,163,505.2	2,505.1	0.0%	(1,161,000.1)	(142,472.5)
47	шагнал урамшуулал	300.0	-	8,622.0	0.0%	8,622.0	8,322.0
48	Тооцооны зөрүү	(30.1)	-	29.2	0.0%	29.2	59.3
49	найдваргүй авлагын зардал	-	-	-	0.0%	-	-
50	Хэвийн бус хорогдол	18,920.6	-	6,419.1	0.0%	6,419.1	(12,501.5)
51	ҮАБЗ-Банкны гүйлгээний шимтгэлийн зардал	2,396.4	-	1,216.6	0.0%	1,216.6	(1,179.8)
52	Бараа, материалын хасалдуулгын зардал	-	-	-	0.0%	-	-
53	Хандив тусламжийн зардал	21,238.4	-	211.1	0.0%	211.1	(21,027.3)
54	27-р байрны зардал	36,385.1	-	-	0.0%	-	(36,385.1)
55	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих	-	-	-	0.0%	-	-
56	Ахмадын зардал	-	31,805.0	-	0.0%	(31,805.0)	-
57	Урамшууллын зардал	-	-	-	0.0%	-	-
Зардлын дүн		36,085,707.7	62,972,010.5	40,623,117.0	100%	(22,348,893.5)	4,537,409.3

2023 оны ЭХЖилийн байдлаар 62.9 тэрбум төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 40.6 тэрбум төгрөгийн зардал гарган ажиллаж 22.3 тэрбум төгрөгийн зардал хэмнэсэн боловч 2022 оны мөн үеэс 4.5 тэрбум төгрөгөөр зардал хэтэрсэн үзүүлэлттэй байна. Тайлан хугацаанд цементийн үйлдвэрлэл 59.6 мянган тонноор, чулуунцар үйлдвэрлэл 38.4 мянган тонноор, шохойн үйлдвэрлэл 858 тонноор үйлдвэрлэлийн төлөвлөгөө тасарч үүний улмаас хувьсах зардлууд болох шатах тослох материал, нүүр түлш, түүхий эд материал, цахилгаан, ус, туслах материал зэрэг зардлууд болон сэлбэг материалын зардал,

=

бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлууд дийлэнх болох 19.6 тэрбум төгрөгийн зардлын хэмнэлт үүсгэсэн болно.

Томоохон зардлуудыг задлан шинжилгээ хийхэд:

НҮҮРС ТҮЛШ

2023 оны эхний хагас жилийн байдлаар шохой үйлдвэрлэлтийн нүүрсний орцын норм төлөвлөлтөөс 0.02 -р хэмнэж, чулуунцар үйлдвэрлэлтийн нүүрсний орцын норм төлөвлөлтөөс 0.02 -р хэтэрсэн байна.

Үзүүлэлт	Орцын норм			
	2021 гүй	2022 гүй	2023 гүй	2023 төл
Чулуунцар	0.19	0.18	0.20	0.18
Шохой	0.25	0.32	0.26	0.28

Доорхи хүснэгтээс харахад шохой үйлдвэрлэлтийн гүйцэтгэл төлөвлөлтөөс 857.58 тонноор дутуу үйлдвэрлэсэн хэдий ч эхний хагас жилийн байдлаар орцын нормоос 240 тн нүүрс хэмнэсэн байна. Харин чулуунцар үйлдвэрлэлт төлөвлөгөөнөөс бага үйлдвэрлэлт хийж нүүрсний зарцуулалт мөн гүйцэтгэлээр бага байна.

Үзүүлэлт	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт				Нүүрсний зарцуулалт			
	2021 гүй	2022 гүй	2023 гүй	2023 төл	2021 гүй	2022 гүй	2023 гүй	2023 төл
Чулуунцар	150,849.21	188,075.95	127,047.50	165,500.00	28,449.86	31,109.07	23,046.42	29,790.00
Шохой	18,891.69	27,546.04	22,342.42	23,200.00	4,771.26	8,807.75	5,758.84	6,496.00

Үйлдвэрлэлтэнд зарцуулсан нүүрсний нэгжийн үнэ нь төлөвлөлтөөс 29,214.21 төгрөгөөр буурсан бол өмнөх оны мөн үеэс 33,280.66 төгрөгөөр өссөн гүйцэтгэлтэй харагдаж байна.

Үзүүлэлт	Нүүрсний нэгж үнэ					
	2021 гүй	2022 гүй	2023 гүй	2023 төл	2023г/2023г	2023г/2022г
Чулуунцар	89,545.18	103,454.19	163,782.11	200,000	(36,217.89)	60,327.91
Шохой	170,350.36	171,556.06	177,789.47	200,000	(22,210.53)	6,233.40
Нийт	129,947.77	137,505.13	170,785.79	200,000.00	(29,214.21)	33,280.66

Эхний хагас жилийн гүйцэтгэлээр 4,798.45 сая төгрөгийн зардалтай ажилласан нь төлөвлөлтөөс 2,458.75 сая төгрөгөөр буюу нэгжийн үнээс 962.60 сая төгрөгөөр, тоо хэмжээнээс 1,496.15 сая төгрөгөөр тус тус буурсан нь чулуунцар болон шохойн үйлдвэрлэлт төлөвлөсөнөөс гүйцэтгэл нь бага байгаатай холбоотой юм.

Үзүүлэлт	Тоо хэмжээ		Нийт үнэ /сая.төг/		Хэлбэлзэл /сая.төг/		
	2023 гүй	2023 төл	2023 гүй	2023 төл	Бүгд	Нэгжийн үнээс	Тоо хэмжээнээс
Чулуунцар	23,046.42	29,790	3,774.59	5,958	(2,183.41)	(834.69)	(1,348.72)
Шохой	5,758.84	6,496	1,023.86	1,299	(275.34)	(127.91)	(147.43)
Нийт	28,805.26	36,286	4,798.45	7,257	(2,458.75)	(962.60)	(1,496.15)

=

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАРДАЛ


Компанийн дүнгээр 2023 оны ЭХЖилийн байдлаар 25446,0 мян.кВт буюу 5940,4 сая төгрөгийн цахилгаан зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 18000,6 мян. кВт буюу 4116,2 сая төгрөгийн цахилгаан зарцуулж төлөвлөлтөөс 7439,9 мян. кВт буюу 1824,7 сая төгрөг хэмнэсэн. Нэгж үнээс 87,1 сая төгрөг хэмнэсэн. Чулуунцарын үйлдвэр 3-р сарын 1-нээс ажиллаж 53000 тн чулуунцар үйлдвэрлэхээр төлөвлөсөн боловч 3-р сарын сүүлээс ажиллаж 3721,9 тн чулуунцар үйлдвэрлэж цахилгааны зарцуулалт буурснаас 1737,1 сая.төг хэмнэсэн мэт харагдаж байна.

Хүснэгт 1. 2023 оны цахилгаан зарцуулалт

№	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он	2023 он		Хэлбэлзэл	хамаарал	
				төл	гүй		Үнээс	Тоо хэмжээнээс
I. Биет үзүүлэлт								
1	Цахилгаан	мян.кВт	28,205.0	25,446.0	18,006.1	(7,439.9)	70.8%	
2	Хувьсах	мян.кВт	26,835.4	24,018.6	16,387.8	(7,630.8)	68.2%	
3	Тогтмол	мян.кВт	1,369.6	1,427.4	1,618.3	190.9	113.4%	
II. Өртгийн үзүүлэлт								
1	Цахилгаан	сая.төг	4,905.2	5,940.4	4,116.2	(1,824.17)	69.3%	(87.1)
2	Хувьсах	сая.төг	4,663.1	5,607.7	3,683.1	(1,924.59)	65.7%	(143.0)
3	Тогтмол	сая.төг	242.1	332.7	433.2	100.42	130.2%	55.9
III. Тарифын үзүүлэлт								
1	Цахилгаан	төг						
	Тариф	төг	173.9	233.5	228.6	(4.85)	97.9%	

Цахилгаан зарцуулалтыг тарифын ангиллаар нь авч үзвэл:

Цахилгаан зарцуулалт тарифаар /тарифаар/



Нийт зарцуулалтын 46.0 хувийг 06-17 цагийн зарцуулалт, 26 хувийг 17-22 цагийн зарцуулалт, 22 хувийг 22-06 цагийн зарцуулалт, чадлын тариф 6 хувийг эзэлж байна. 17-22 цагийн хооронд цахилгаан зарцуулалтын оргил ачааллын үе бөгөөд тухайн цагт зарцуулсан цахилгааны тариф өндөр мөн чадлын тарифаар давхар төлбөр тооцогддог тул цехүүд тухайн цагуудад цахилгааны хэрэгцээг багасгаж ажиллах шаардлагатай.

Цахилгаан зарцуулалтыг тарифын ангилалтаар нь өмнөх онтой харьцуулбал:



Өмнөх үеийн мөн үетэй харьцуулахад цагийн зарцуулалтууд 17-22 цагийн хооронд дахь цахилгааны зарцуулалт 0,8 хувиар өсч 22-06 цагийн хоорондох зарцуулалт ихэссэн нь үйлдвэр хэвийн жигд ажиллаж эхлээгүйгээс шалтгаалсан.

Цахилгааны үнийн хэлбэлзэл:

Графикаас харахад сар бүрийн цахилгаан үнэ харилцан адилгүй байна. Цахилгаан цахилгааны дундаж үнийн өөрчилтөнд 3-н шатны тоолуураар зарцуулсан цахилгааны зарцуулалт ихээхэн нөлөө үзүүлдэг. 2023 оны төлөвлөлтийн үнээс хэтрээгүй байна.

:Зураг 3. Цахилгаан эрчим хүчний үнийн хэлбэлзэл



Нийт цахилгаан зарцуулалтын хэмжээгээр задлан харвал:

✓ Цементийн үйлдвэрлэлийн цех	- 5551,6 мян.кВт буюу	38,2 %
✓ Чулуунцарын үйлдвэрлэлийн цех	- 7960,5 мян.кВт буюу	54,8 %
✓ Шохойн үйлдвэрлэлийн цех	- 439,5 мян.кВт буюу	3,3 %
✓ Бусад цех нэгж	- 550,7 мян.кВт буюу	3,7 %
ДҮН	- 14502,4 мян.кВт буюу	100% тус тус эзэлж

байна.


УСНЫ ЗАРДАЛ:

Компанийн дүнгээр 2023 оны ЭХЖилийн байдаар төлөвлөгөөгөөр 243,3 сая төгрөгийн ус зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 147,6 сая төгрөгийн ус зарцуулж төлөвлөлтөөс 95,7 сая төгрөг хэмнэсэн. Тоо хэмжээний хэмнэлтээс 17,6 мян.м3 ус хэмнэгдэж 15,2 сая төгрөг хэмнэж төлөвлөгөөт нэгж үнэ 676,4 төгрөгөөр хэмнэснээс нийт 38,3 сая төгрөгөөр хэмнэсэн. Нэгж үнэ хэмнэгдсэн шалтгаан нь гүний худагны ус хэрэглэснээс нөлөөлсөн.

Хүснэгт 1. Усны зардал ЭХЖилийн байдлаар гүйцэтгэл харьцуулалт

№	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он	2023 он		Хэлбэлзэл	хамаарал	
				төл	гүй		Үнээс	Тоо хэмжээнээс
I. Биет үзүүлэлт								
1	Цэвэр бохир ус	мян.м2	53,025.0	78,059.1	60,500.0	(17,559.1)	78%	
2	Цэвэр ус	мян.м3	38,034.0	57,965.1	44,030.0	(13,935.1)	76.0%	
4	Гүний худаг	мян.м3	17,266.0	17,740.0	20,199.0	2,459.0	113.9%	
5	Гавшгай ус	мян.м3	20,768.0	40,225.1	23,831.0	(16,394.1)	59.2%	
6	Бохир ус	мян.м3	14,991.0	20,094.0	16,470.0	(3,624.0)	82.0%	
II. Өртгийн үзүүлэлт								
1	Цэвэр бохир ус	сая.төг	133.92	243.30	147.65	(95.7)	60.7%	(38.3)
2	Цэвэр ус	сая.төг	76.96	166.95	87.87	(79.1)	52.6%	(38.9)
3	Бохир ус	сая.төг	56.97	76.36	59.77	(16.6)	78.3%	0.6
III. Тарифын үзүүлэлт								
1	Цэвэр ус							
	Тариф	төг	3,705.6	4,150	3,687	(462.9)	89%	
2	Бохир ус							
	Тариф	төг	3,800	3,800	3,629	(170.7)	96%	
3	Нийт ус							
	Тариф	төг	2,525.7	3,116.9	2,440.5	(676.4)	78.3%	

Усны зарцуулалтыг графикаар харьцуулвал:



Сэлбэг материал:

2023 оны ЭХЖилийн байдлаар сэлбэг материалын зардалд 7.7 тэрбум төгрөг төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 2.7 тэрбум төгрөгний сэлбэг материал зарцуулагдсан болно.

Нийт сэлбэг материалын 68.2% механик сэлбэг, 24.9% цахилгаан сэлбэг, 6.9% БҮТЭЦ-ийн зардал тус тус эзлэж байна.

Зардал	2022	2023	2023	Эзлэх хувь	Хэлбэлзэл	
	гүйц	төл	гүй		2023г/2023г	2023г/2022г
Механик сэлбэг	1,722,165.5	6,046,268.9	1,897,836.8	68.2%	(4,148,432.1)	175,671.3
Цахилгаан сэлбэг	278,574.9	1,537,349.4	693,516.0	24.9%	(843,833.4)	414,941.1
БҮТЭЦ	280,783.5	166,232.4	192,632.2	6.9%	26,399.8	(88,151.3)
Нийт	2,281,523.9	7,749,850.7	2,783,985.0	100%	(4,965,865.7)	502,461.1

Механик сэлбэг материал:


№	Цех, хэлтэс	2017	2018	2019	2020	2021	2022	2023 төл	2023	Хэтрэлт хэмнэлт	Биелэлт
1	Хөтөл 1	9,033.3	2,030.0	137,258.2	19,342.9	6,780.1	27,700.7	270,759.6	159,340.1	(111,419.5)	58.8%
	Хөтөл 2	79,489.7	175,362.6	118,251.2	76,220.9	44,891.5	63,096.4	-	6,309.6	6,309.6	0.0%
	Баяжуулалт	-	-	-	-	-	5,596.1	-	-	-	0.0%
	Уурхайн бутлуур	-	-	-	-	-	30,404.4	-	-	-	0.0%
	Уурхайн тээвэр	-	-	-	-	-	-	403,992.7	202,173.5	(201,819.2)	50.0%
	Сланз	50.7	-	7,705.3	7,603.6	7,724.5	-	-	820.4	820.4	0.0%
	АММБ	131,745.4	172,665.0	150,631.3	148,064.9	152,843.3	264,910.9	273,917.3	63,637.4	(210,279.9)	23.2%
Уурхай	220,319.2	350,057.6	413,845.9	251,232.2	212,239.4	391,708.4	948,669.6	432,280.9	(516,388.7)	45.6%	
2	Шохой	15,339.4	11,256.2	20,871.4	37,858.7	21,492.5	129,292.7	158,797.0	84,146.8	(74,650.2)	53.0%
	Шохойн бутлуур	20,849.8	7,940.2	15,749.6	19,332.6	15,692.4	29,557.8	80,325.9	56,274.6	(24,051.4)	70.1%
	Шохойн үйлдвэр	36,189.2	19,196.4	36,621.0	57,191.3	37,184.9	158,850.5	239,122.9	140,421.4	(98,701.5)	58.7%
3	Чулуунцар	59,217.4	184,200.6	211,859.1	87,155.5	207,564.4	546,505.8	1,685,670.1	46,031.4	(1,639,638.7)	2.7%
	Бутлуур ХА	67,934.3	156,467.4	7,439.7	5,554.2	48,230.0	72,308.3	423,453.9	110,385.1	(313,068.7)	26.1%
	Хуурай хольц	38,279.6	143,350.8	53,169.3	19,086.4	57,736.9	92,532.6	717,849.3	825,357.5	107,508.2	115.0%
Чулуунцарын үйлдвэр	165,431.4	484,018.9	272,468.1	111,796.1	313,531.3	711,346.6	2,826,973.2	981,774.0	(1,845,199.2)	34.7%	
4	Цемент	224,458.8	272,047.9	226,653.7	96,178.4	96,712.4	284,274.1	948,741.0	213,240.5	(735,500.6)	22.5%
	Компрессор	886.0	10,032.9	5,128.9	1,888.7	5,231.6	77,078.9	172,265.7	47,694.0	(124,571.8)	27.7%
	Савлах	4,299.8	29,332.6	29,467.5	14,480.3	14,842.0	28,007.2	197,016.3	32,924.9	(164,091.3)	16.7%
Цементийн үйлдвэр	229,644.5	311,413.5	261,250.2	112,547.5	116,786.0	389,360.2	1,318,023.1	293,859.4	(1,024,163.7)	22.3%	
5	Дулаан	13,679.7	32,147.5	-	-	-	-	-	-	-	0.0%
6	Механик	10,151.3	5,031.2	10,576.2	9,935.7	10,177.3	37,816.8	43,269.5	23,131.0	(20,138.5)	53.5%
	Цахилгаан	808.9	326.4	348.1	810.1	229.5	2,878.0	-	3,398.1	3,398.1	0.0%
	КиПиА	111.6	-	-	502.4	3.4	230.9	-	99.3	99.3	0.0%
ЭНЦех	11,071.8	5,357.6	10,924.3	11,248.1	10,410.2	40,925.8	43,269.5	26,628.4	(16,641.1)	61.5%	
7	Захиргаа	220.4	4,869.3	2,977.7	9,358.8	8,200.0	1,841.3	-	6,552.4	6,552.4	0.0%
8	СПЛ	134.1	41.0	171.9	4,511.5	2,791.5	3,037.5	-	352.8	352.8	0.0%
9	Буулгалт	7,783.2	3,098.6	26,505.9	144,272.0	17,612.0	24,721.2	670,210.5	10,030.0	(660,180.5)	1.5%
10	Аж ахуй	91.1	530.5	52.6	4.9	357.9	271.3	-	271.1	271.1	0.0%
	Буудал	12.8	-	-	-	-	-	-	-	-	0.0%
	Гуанз	-	87.5	350.6	19.7	28.0	104.0	-	5,666.4	5,666.4	0.0%
Аж ахуйн алба	103.9	618.0	403.2	24.6	385.9	375.3	-	5,937.6	5,937.6	0.0%	
Дүн	684,577.4	1,210,818.4	1,025,168.2	702,182.0	719,141.1	1,722,166.8	6,046,268.9	1,897,836.8	(4,148,432.1)	31.4%	

2023 онд ЭХЖилд 6.0 тэрбум төгрөгийн механик сэлбэг материал зарцуулахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 1.9 тэрбум төгрөг зарцуулж 4.1 тэрбум төгрөгөөр хэмнэлт үүссэн буюу төлөвлөгөөний биелэлт 31.4 % байна. Чулуунцарын үйлдвэр 1.8 тэрбум төгрөг, Цементийн үйлдвэр 1.0 тэрбум төгрөг, Уурхай 0.5 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан дийлэнх хувийг эзэлж байна.

2017 оноос 2023 оныг хүртэлх гүйцэтгэлийг харахад 2023 төлөвлөгөөнд механик сэлбэг материалыг хэд өндөр төлөвлөсөн байгаа харагдаж байна. Ерөнхий техникийн хэлтэс нь сэлбэг материалын төлөвлөгөө боловсруулж тухайн жилийн зорилтот түвшин, эдийн засгийн үзүүлэлтэнд тусгадаг тул сэлбэг материалын зардал төлөвлөхдөө судалгаа, норм, засварын ажлын төлөвлөгөөтэй тус тус уялдуулан бодит төлөвлөх шаардлагатай. Мөн 2023 онд тендерин худалдан авалтын ажиллагаа удаашралтай явагдаж байгаагаас шаардлагатай сэлбэг материалууд цаг хугацаандаа худалдан авалт хийгдэхгүй байгаа нь зардал хэт хэмнэсэн мэт харагдахад нөлөөлж байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал:

2023 оны эхний хагас жилд нийт 2,9 тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ авхаар төлөвлөж гүйцэтгэлээр 1,1 тэрбум төгрөгний бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал гарсан. 2023 оны эхний хагас жилд нийт бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний 23%-ийг Шохойн үйлдвэр, 18%-ийг Геологи уул уурхайн хэлтэс, 16%-ийг ХАБЭАБОХэлтэс, 13%-ийг Цементийн үйлдвэр, 8%-ийг Компрессор, 6%-ийг Удирдлага, 5%-ийг Лаборатори, 3%-ийг Уурхай, үлдсэн 8%-ийг бусад цех нэгжүүд эзэлж байна.



Шохойн үйлдвэр ТЭЗҮ боловсруулуулсан ажлын хөлсөнд 162,9 сая төгрөг зарцуулсан. Энэ нь нийт зардлын 14%-ийг эзэлж байна. Гэхдээ 2023 төлөвлөгөөгөөр эхний хагас жилд ТЭЗҮ боловсруулуулах ажил төлөвлөгдөөгүй. Мөн 65,8 сая төгрөгөөр Гэрлийн хэмнэл ХХК-тай хийсэн гэрээний дагуу ажил гүйцэтгүүлсэн нь нийт зардлын 6%-ийг эзэлж байна.

ХАБЭАБОХэлтэс 2023 оны 7-р сард 180,2 сая төгрөгөөр Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажил хийлгэхээр төлөвлөгөөнд тусгасан. Гэхдээ энэ ажил гүйцэтгэлээр эхний хагас жилд 138,4 сая төгрөгийн зардлаар хийгдсэн. Энэ нь нийт зардлын 12%. ХАБЭАБОХэлтэс үйлдвэрийн нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Үүнд 36 сая төгрөг зарцуулсан.

Цементийн үйлдвэрт 2-р тээрмийн засварын ажлыг 123,6 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлсэн. Энэ нь нийт зардлын 10%-ийг эзэлж байгаа. Гэхдээ мөн л энэ ажил 2023 оны эхний хагас жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй.

Геологи уул уурхайн хэлтэс 95,8 сая төгрөгөөр Виртген ангилан олборлолтын ТЭЗҮ хийлгэх үйлчилгээ авсан. Энэ нь нийт зардлын 8%-ийг эзэлсэн. Мөн л энэ зардал тухайн хугацаанд 2023 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй. Мөн Уурхай дээр уурхайн зураглалын хэмжилт хийлгэх ажлын 2023 онд төлөвлөж өгсөнч зардлыг Геологи уул уурхайн хэлтсийн зардалруу хийсэн. Уурхайн зураглалын хэмжилтийг 86,4 сая төгрөгөөр хийлгэсэн нь нийт зардлын 7%-ийг эзэлж байна.

Компрессор дээр даралтат савны баталгаажуулалт хийлгэсэн. Мөн хийн компрессороо засварлуулсан. Эдгээр ажлууд нь 45,7 сая төгрөг, 44,3 сая төгрөгөөр тус тус үйлчилгээ авсан. 2023 оны гүйцэтгэлээр гарсан нийт зардлын 8%-ийг энэ 2 ажил хийлгэсэн зардал эзэлж байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээнд 2023 оны 1-6 сард 2,9 тэрбум төгрөг төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 1,1 тэрбум төгрөг зарцуулсан.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээг жагсаалтаар харуулвал:

№	Ажил үйлчилгээ	2023 ТӨЛ /мян.төг/	2023 ГҮЙЦ /мян.төг/	2023 ГҮЙЦ/2023 ТӨЛ	Хувь	
					2023 гүйц	2023 төл
1	2-р тээрийн өвлийн засварт	-	123,659.07	123,659.07	10%	0%
2	3-р тээрийн гол засварлуулсан ажлын хөлс	-	18,000.00	18,000.00	2%	0%
3	Hyundai R800 экскаватор /техникийн үйлчилгээ	7,500.00	14,545.45	7,045.45	1%	0%
4	Ажлын хөлс /Булжих минерал майнинг/	-	162,981.82	162,981.82	14%	0%
5	Ажлын хөлс /Гэрлийн хэмнэл/	-	65,838.31	65,838.31	6%	0%
6	Ажлын хөлс /Техник импорт/	-	20,000.00	20,000.00	2%	0%
7	Ажлын хөлс /Элемент ХХК/	-	18,116.21	18,116.21	2%	0%
8	Аудитын дүгнэлт	-	20,000.00	20,000.00	2%	0%
9	Байгаль орчны аудит хийх, зөвлөгөө өгөх үйлчилгээ	-	12,200.00	12,200.00	1%	0%
10	Барилгын зураг	-	8,863.64	8,863.64	1%	0%
11	Биологийн олон янз байдлыг Дүйцүүлэн хамгаалах ажлыг х	-	138,457.67	138,457.67	12%	0%
12	Виртген ангилан олборлолт хийх ТЭЗҮ	-	95,800.00	95,800.00	8%	0%
13	Втулка гол сэргээн засуулсан ажлын хөлс	-	10,425.19	10,425.19	1%	0%
14	Гишүүнчлэлийн төлбөр /МУУУА/	-	10,000.00	10,000.00	1%	0%
15	Гишүүнчлэлийн төлбөр /МУХАҮТ/	-	10,000.00	10,000.00	1%	0%
16	Гэрээт ажлын хөлс /ШУТИС ДАТС/	-	39,050.00	39,050.00	3%	0%
17	Даралтат савны баталгаажуулалт	-	45,736.00	45,736.00	4%	0%
